

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Практикт хэрэгжих боломж:

Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилтод тусгагдсан зам тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлөх зохицуулалтыг хуулийн төсөлд өөрчлөн тусгасан бөгөөд хуулийн төсөлд “Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, даатгуулагч болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тээврийн хэрэгслийн өмчлөгчийг заавал даатгалд хамруулахтай харилцааг зохицуулахад оршино” гэж өөрчлөн тусгасан. Ингэснээр зөвхөн замын хөдөлгөөнд оролцож байх үеийн жолоочийн бусдад учруулсан хохиролд нөхөн төлбөр олгодог өнөөгийн зохицуулалтыг өөрчилж гудамж, талбай, авто зогсоолд ч нэгэн адил автотээврийн хэрэгсэл хөдөлгөөнд орсон үед бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг бий болгох зохицуулалтыг төсөлд тусгав.

Жолоочийн даатгалын хураамжийг тогтоохдоо жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг хамгийн бага байлгах зарчмыг баримталж, даатгалын хураамж, үнэлгээний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, инфляцын түвшин, эрсдэлийн түвшинтэй уялдуулан тухай бүр тогтоох зохицуулалтыг бий болгох, үүний үр дүнд даатгалын хураамжийг даатгалын мэргэшсэн ажилтнуудын тооцоолол, саналд үндэслэн, эрсдэлд суурилсан, илүү нарийвчлалтай, үндэслэлтэй тооцох боломжтой болох юм.

Цахимаар болон аливаа технологийг ашиглан даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр шийдвэрлэх, даатгалын тохиолдлыг баталгаажуулж болох эрх зүйн орчныг бүрдүүлж, мэдээллийн сангийн зохицуулалтыг сайжруулснаар хөгжингүй улс орнуудад ашиглагдаж буй орчин үеийн шинэ даатгалын үйлчилгээ болох даатгалын тохиолдлыг баталгаажуулах дронууд, хурууны хээ, тоон гарын үсгээр баталгаажуулсан ухаалаг даатгалын гэрээ, хохирол үнэлэх телематик төхөөрөмж, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн систем зэрэг технологиуд бий болж даатгалын компаниудын үйл ажиллагааны зардал буурах нөхцөлийг бүрдүүлнэ.

Даатгалын нөхөн төлбөр олгохтой холбогдох үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтийг хангуулж ажилласнаар даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийн хугацааны удаашралтай байдал, даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалздаг байдал байхгүй болох боломжтой болно.

Даатгагч нь даатгалын хохирол үнэлэгч этгээдийг заавал томилох үүрэгтэй бөгөөд тухайн хохирол үнэлэгчээр бие даасан, тусдаа хуулийн этгээд ажилладаг өнөөгийн зохицуулалтыг өөрчилж даатгалын компанийн даатгагчийн томилсон хохирол үнэлэгч байх эсхүл хөндлөнгийн хохирол үнэлэгч байхаар төсөлд тусган

даатгагчийн хохирол үнэлэгч нь нөхөн төлбөрийн хэмжээг эхэлж тооцох ба даатгуулагч санал нийлэхгүй, маргаантай тохиолдолд даатгалын хөндлөнгийн хохирол үнэлэгчид хандах эрхтэй байхаар өөрчлөн найруулав.

Холбоо нь даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан, даатгалын тохиолдлын буруутай этгээд тодорхойгүй болон хууль тогтоомжид заасан бусад тохиолдлуудын улмаас хохирсон этгээдэд даатгалын нөхөн төлбөр олгох үүрэгтэй байхаар төсөлд тусгав. Энэхүү Холбооны үйл ажиллагааг даатгагч нар өөрсдөө хариуцан явуулснаар хохирогч даатгалтай болон даатгалгүй аль ч тохиолдолд даатгалын нөхөн төлбөр авах боломжийг бүрдүүлж, улмаар автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас хохирогчийн эрх ашиг хамгаалагдан, даатгалын салбарын нэр хүнд өсөх, улмаар даатгагч нар шуурхай алба зэрэг нэгдсэн зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх давуу тал бүрдэнэ.

Жолоочийн даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулснаар уг даатгалын чанар, үйлчилгээ сайжрах, даатгалын хураамж, үнэлгээ нь олон улсын жишигт нийцсэн, бодит үнэлэмжээр тогтох, төрийн оролцоо багасах, даатгалын тохиолдол гарсан нөхцөлд түргэн шуурхай шалган хохирлыг үнэлэх, богино хугацаанд нөхөн төлбөр олгох, зам тээврийн ослын аливаа тохиолдолд хохирогчийн эрх ашиг хамгаалагдах юм.

Иймд эдгээр шинэлэг зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх,

хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Манай улсын хувьд 2012 онд батлагдсан Жолоочийн даатгалын тухай хуулиар жолоочийн хариуцлагын албан журмын даатгал буюу тээврийн хэрэгсэл эзэмшигч болон жолооч нар нь зам тээврийн хөдөлгөөнд оролцох үедээ гуравдагч этгээдэд учруулж болзошгүй гэм хор, амь насны эрсдэлээс хариуцлагаа даатгуулахтай холбогдох харилцааг зохицуулж ирсэн.

Гэвч практикт тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэх, олон улсын чиг хандлагад нийцүүлэн хуулийн зохицуулалтыг сайжруулан шинэчлэн найруулах шаардлага тулгарсан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг хэрэгжүүлэхэд холбогдох этгээдүүдийн зохицуулалт хэвээр хадгалагдахаар байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс **“зардал тооцох” шалгуур** үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
-----	------------------	------------------------	-----------------

1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1, 4, 5, 9, 10, 11, 22, 23 дугаар зүйл	Хуулийн зохицуулалтад хамрагдах байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Жолоочийн даатгалын тухай хуулийн зохицуулалтыг нарийвчлан, дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

1. Хуулийн зарчмыг олон улсын сайн туршлагад үндэслэн тогтоох;
2. Хуулийн нэр томъёоллын тодорхойлолтыг сайжруулах;
3. Даатгалын үнэлгээ, хураамж тооцох аргачлал, итгэлцүүрийг хуулийн зарчмын өөрчлөлттэй холбоотойгоор шинэчилж найруулах;
4. Албан журмын даатгагчдын холбоог өөрчлөн зохион байгуулж, түүний статус, эрх, үүргийг илүү нарийвчлан тодорхойлох;
5. Даатгалын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх болон аливаа дэвшилтэт технологийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

6. Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах;
7. Даатгалын мэдээллийн сангийн зохицуулалтыг шинэчлэх;
8. Даатгагч, даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдох зохицуулалтыг сайжруулах;
9. Нөхөн төлбөр олгох зохицуулалтыг илүү шуурхай, хялбаршуулах чиглэлээр сайжруулах;
10. Шинэ хууль хүчин төгөлдөр болсонтой холбоотой шилжилтийн зохицуулалт, дагаж мөрдөх журмыг тусгана.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Хуулийн зарчмыг олон улсын сайн туршлагад үндэслэн тогтоох хүрээнд:

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн даатгалд заавал хамрагдах” гэж тээврийн хэрэгслээ дагасан зохицуулалтыг бий болгож, 4.1.5-д “жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах” гэж тус тус төсөлд тусгасан байна.

Ийнхүү олон улсын сайн туршлагад нийцүүлэн хуулийн зарчимд шинээр заалт нэмэх байдлаар хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн нэр томъёоллын тодорхойлолтыг сайжруулах хүрээнд:

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “жолоочийн даатгалын тохиолдол /цаашид “даатгалын тохиолдол” гэх/” гэж автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж, хариуцлага хүлээх тохиолдлыг” гэж тодорхойлсноор гудамж, талбай, авто зогсоолд тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд орох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөр олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “нэхэмжлэгч” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.2-т заасныг;”, 3.1.6-д “хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой нэгдсэн зохион байгуулалтын бүтэц буюу холбоо” /цаашид “Холбоо” гэх / гэж жолоочийн даатгалд хамрагдаагүй, эсхүл гэрээний хугацаа дууссан түүнчлэн даатгалын тохиолдол гаргасан этгээд тодорхойгүй зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл авсан даатгагч нар хамтарч энэ хуульд заасны дагуу байгуулсан хуулийн этгээдийг,” гэж тодорхойлж нэр томъёоллыг сайжруулсан байна.

Даатгалын үнэлгээ, хураамж тооцох аргачлал, итгэлцүүрийг хуулийн зарчмын өөрчлөлттэй холбоотойгоор шинэчилж найруулах хүрээнд:

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт даатгалын үнэлгээний доод хэмжээ болон даатгалын хураамжийг хэрхэн тогтоох талаар тусгасан байна. Тухайлбал хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо даатгалын суурь хураамжийн хэмжээг итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцох бөгөөд даатгалын хураамж тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооноос ирүүлсэн саналыг харгалзан Хороо батална.” гэж тусгагдсаны дагуу инфляцын түвшин, эрсдэлийн түвшинтэй уялдуулан тухай бүр хураамжийн хэмжээг тогтоох уян хатан нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Албан журмын даатгагчдын холбоог өөрчлөн зохион байгуулж, түүний статус, эрх, үүргийг илүү нарийвчлан тодорхойлох:

Даатгалын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгаар Албан журмын даатгагчдын холбоо”-г “Заавал даатгалын холбоо” болгон өөрчилж, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөн, эрх, үүргийг нь тодорхойлсон. Харин Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өнөөгийн Албан журмын даатгагчдын холбооны хэрэгжүүлж буй нэгэн үүрэг болох даатгалгүй этгээд бусдад хохирол учруулсан тохиолдолд жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох үүргийг даатгагчдын байгуулсан дундын хуулийн этгээдэд шилжүүлж, даатгагчид тухайн хуулийн этгээд буюу Холбоог бий болгохоор төсөлд тусгасан.

Даатгалын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх болон аливаа дэвшилтэт технологийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгох:

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2-т, 8 дугаар зүйлийн 8.1-д тус тус даатгалын гэрээ цахимаар байгуулах, даатгалын баталгааг цахимаар хүргүүлж болох талаар тусгасан бөгөөд хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2-т, 19 дүгээр зүйлийн 19.1-д тус тус даатгалын тохиолдол баталгаажуулах, хохирлын хэмжээг тодорхойлод цахим болон аливаа технологийг ашиглаж болно гэж тусгасан байна.

Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах

Даатгалын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгаар Заавал даатгалын холбоо нь заавал даатгалын баталгаат санг удирдах бөгөөд өнөөгийн жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх, сангаас заавал даатгалын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой судалгаа, сургалт, сурталчилгааг хэрэгжүүлэхээр заасан.

Даатгалын мэдээллийн сангийн зохицуулалтыг шинэчлэх

Хуулийн төслийн 23 дугаар зүйлд Жолоочийн даатгалын мэдээллийн сантай холбоотой зохицуулалтуудыг шинэчлэн тусгасан бөгөөд мэдээллийн санд бүртгэх, хөтлөх мэдээллийн төрөл, ангиллыг нэмэгдүүлж, холбогдох зохицуулалтыг сайжруулсан.

Даатгаагч, даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдох зохицуулалтыг болон нөхөн төлбөр олгох зохицуулалтыг илүү шуурхай хялбаршуулах чиглэлээр сайжруулах

Хуулийн төсөл дэх “Даатгалын зарчим”-д өөрчлөлт оруулж тээврийн хэрэгслийг дагасан зохицуулалтыг бий болгосон бөгөөд тээврийн хэрэгслийн жолооны хүрдний ард даатгалтай, даатгалгүй аль ч этгээд жолоодож байсан даатгалын нөхөн төлбөрийг олгох зохицуулалт хэвээр байхаар тусгасан.

Мөн хуулийн төслийн 20 дугаар зүйлд нөхөн төлбөр олгох үйл ажиллагааны талаар нарийвчлан зохицуулсан ба нөхөн төлбөр шийдвэрлэх хуулийн хугацааг багасгасан.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 1, 4, 9, 10, 11, 22 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилгоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд төрийн байгууллага болон иргэд, төрийн бус байгууллага, судлаачдын төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг авсан.

Мөн холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь зам, тээврийн ослын болон авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, даатгуулагч болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор автотээврийн хэрэгслийн **өмчлөгчийг заавал даатгалд хамруулахтай** холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж тодорхойлсноор тээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгуулах, ингэснээр жолооч даатгуулах зохицуулалт өөрчлөгдөн даатгуулагчдад илүү ойлгомжтой, тодорхой болж, даатгалын хамрагдалт нэмэгдэх үр нөлөөг үзүүлэх юм.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд жолоочийн даатгалын зарчмыг дараах байдлаар томъёолсон:

- автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн даатгалд заавал хамрагдах;
- хохирогчид нөхөн төлбөрийг шуурхай олгох;

- жолоочийн даатгалд даатгуулаагүй этгээдийн автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх;
- зам, тээврийн ослын болон авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох;
- жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгах;
- жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөлтэй даатгагч нь даатгуулагчийн жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ байгуулах хүсэлтээс татгалзахгүй байх.

Зөвхөн автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь даатгалд хамрагдах, хамрагдалтад хяналт тавих, мөн жолоочийн даатгалын үйл ажиллагааны зардлыг боломжит хамгийн бага түвшинд байлгаснаар даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчдод даатгалын үр шимийг илүү хүртээх боломж бүрдэнэ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд даатгалын үнэлгээний доод хэмжээг дараах хэмжээтэй байхаар тусгасан:

- хохирогчийн амь нас, эрүүл мэндийн хувьд нэг хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин, нэгээс дээш хохирогчтой бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг хүртэл;
- хөрөнгийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг хүртэл;

Даатгалын үнэлгээний доод хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулснаар цаг үеийн нөхцөл байдалд нийцсэн үнэлгээ тогтох бөгөөд практикт хэрэгжих бүрэн боломжтой.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд даатгалын хураамжийг хэмжээг тогтоохдоо:

- Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан даатгалын үнэлгээнд ногдох даатгалын суурь хураамжийн хэмжээг Хороо автотээврийн хэрэгслийн ангиллаас хамааруулан тогтооно.
- Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо даатгалын суурь хураамжийн хэмжээг итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцох бөгөөд даатгалын хураамж тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг Даатгалын тухай хуульд заасан Заавал даатгалын холбооноос ирүүлсэн саналыг харгалзан Хороо батална.

Инфляцийн түвшин, даатгалын эрсдэлийн түвшинтэй уялдуулж, уян хатан зарчимтайгаар тухай бүр даатгалын мэргэжлийн этгээдүүдийн санал, тооцоололд үндэслэн тогтоосноор зах зээлд бодит үнэ ханшийг бий болгох ба практикт хэрэгжих бүрэн боломжтой.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд жолоочийн даатгалын үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооноос хяналт тавихтай холбогдох үйл ажиллагааг тусгасан бөгөөд жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгагчид зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах харилцааг тусгаснаар даатгагчид илүү хариуцлагажиж, хэрэглэгчдэд илүү чанартай даатгалын үйлчилгээ хүрэх ба практикт хэрэгжих боломжтой.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 22 дугаар зүйлд даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан, даатгалын тохиолдлын буруутай этгээд тодорхойгүй нөхцөлд хохирогчийн эрхийг хамгаалах, нөхөн төлбөр олгохтой холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд энэхүү үүргийг даатгалын компаниуд хэрэгжүүлэх буюу хохирогчийн эрхийг хамгаалах нэгдсэн зохион байгуулалтын бүтцийг бий болгох үүргийг даатгагчид хүлээсэн. Ингэснээр зам тээврийн ослын хохирогч аль ч тохиолдолд нөхөн төлбөр авах, нөгөөтэйгүүр даатгалын компаниудын нэр хүнд өсөх, даатгалын хамрагдалт нэмэгдэх давуу талыг бий болгох ба практикт хэрэгжих бүрэн боломжтой байна.

3. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, анализ хийсэн болно.

Жолоочийн даатгалын тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлагатайг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдсэн 8 бүлэг, 26 зүйлтэй байна.

Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн тус хуулийн төслийг дагалдан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулагдсан.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасан шаардлагад нийцсэн байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байна.

Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
-----	--------	---------	---------------

1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.

12	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
13	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
14	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгасан.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг СЗХ-оос боловсруулсан “Жолоочийн даатгалын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбар, санал болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах **Дүгнэлтийг** боловсрууллаа:

Дүгнэлт:

Зорилгод хүрэх байдал: Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна.

Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал: Хуулийн төсөлд хуулийн зарчмыг олон улсын сайн туршлагад үндэслэн тогтоож, хуулийн нэр томъёоллын зарим асуудалтай талыг шийдвэрлэн сайжруулж, даатгалын үнэлгээний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж, даатгалын хураамжийг мэргэжлийн этгээдүүдийн тооцоолол саналаар тухай бүр уян хатан байдалтайгаар эрх бүхий байгууллагаас тогтоож, хохирогчийн эрх ашгийг хамгаалах зохион байгуулалтыг бий болгож, даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээнд цахим технологи ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, даатгалын тохиолдол баталгаажуулах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг хялбаршуулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгон тусгасан сайшаалтай байна.

Ойлгомжтой байдал: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдсан ойлгомжтой байна.

Харилцан уялдааг хангасан байдал: Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Судалгаа, статистик мэдээлэл

1. Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2024 он.
2. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2024 он.
3. Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2024 он. СЯ, СЗХ
4. Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2024 он.
5. Жолоочийн даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага, Тандан судалгаа хийсэн үнэлгээ. 2024 он.

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Зөрчлийн тухай хууль;